

.....сургуулийн.....ангийн сурагч..... овогтой.....

“А” ХУВИЛБАР

80 МИНУТ

Эр зориг

Нэг мянга есөн зуун дөчин дөрвөн оны зуд ёстой л гамшиг байлаа. Хар бичин жилийн зунаас эхлэн, ган гачиг нүүрлэж, тал говийн цагаан зээр, тарвага, зурам үй олноороо харангадаж дуусаад, мэнд үлдсэн мал амьтад арайхийж намартай золгов. Ангамал газраас хошуу хатгах өвс олдохгүй өлдөж явсаар, өвөлтэйгээ эрт залгаж, хавсаргатайгаа <<ханьсаж>> авлаа.

Дөнгө өвгөнийх гурван сайхан хүүтэй айл байлаа. Том нь айл орон болж, өрх тусгаарласан. Тэрхэн хоёр хүүгийнхээ хүчинд энэ айл аргатай байгаа ажээ.

Өвлийн дунд сарын шинийн гуравны шөнө айхтар их цас оржээ. Өглөө босоход, гэрийн хаалгыг цас дараад, хөгшин банхар нь шахаж хэвтсэн байлаа. Өвгөн, харчуулаа сэрээгээд, хамжиж түлхсээр хаалгаа нээв. Өвөлжөөнд тэгнэсэн хэдэн шургааг дотогшоо хотойгоод, бууцаа даран унажээ. Дороос нь малаа хөдөлгөж, хотоо тойруулан цас зөөв. Өдөржин тэмцэлдсээр хэсэг газрыг хуурайлан, хөрсний өнгө гаргалаа. Орой болжээ. Ганц гэрийн тооноор утаа хөвөрч, аяга бүлээн цайтайгаа залгалаа. Бүхэл мах чанаж, өтгөн шөлөнд дотроо бүлээцүүлэв.

Арын гүвээн дээр гарч, орчныг тандаж суусан отгон хүү нь баргар царайлан орж ирээд, “Доод өвөлжөөний хоёр гэрээс утаа гарахгүй өдөржин өнжлөө. Би оччихоод ирье!” гэв. Дөнгө өвгөн хариу хэлсэнгүй. Самган ч дуугарсангүй. Бусдын төлөө гэсэн сэтгэлтэй явах нь хүний ёс гэдгийг мэдэх, хүүхэд биш, насанд хүрсэн эр хүн өөрөө мэдэг дээ! гэж бодсон билээ.

Хуучны хавирган сар ёрдойж, хүйтний эрч чангарчээ. Тэнгэрийн одод үзэсгэлэнгээ гайхуулах мэт, эсвэл тавлан тохуурхах мэт улам жавхаажин тодорчээ. Алсад чонын дуу. Элдвийг бодож явсан, идэр залуу айсангүй. Өвөлжөөний чигийг барин зүтгэсээр нэлээн ойртож ирлээ. Алсаас бөг бөг хуцдаг айлын ноход чимээ алга. Гэтэл цасны нуранга дундаас хад чулуу шаргих чимээ гарч, хээрийн амьтны эхүүн үнэр үнэртэх шиг болов. Отгон залуу Очирхүүд оготор саран хань болсонгүй. Чимээ гарсан зүгт чих тавин суутал, эвэр нь ургаж гүйцсэн халиун буга хэдэн зоргол, согоогоо дагуулчихсан цас туучин зүтгэж байлаа. Сүрэг чононоос зугтан, амь дүйж яваа амьтдыг хараад, Очирхүүгийн өрөвч сэтгэл нь зулгаав.

Амь тэмцэн зугтсан буганууд. Араас нэхэн хөөсөн чононууд. Яах ийхийн зуургүй нөмрөөд иржээ. Очирхүүгийн замд солбилцож, яг энд уулзах учиртай байжээ. Залуу эр бугаа мөрнөөсөө мулталж, хадан дээр гарлаа. Ирж яваа чононуудыг угтуулан, өөдөөс нь сөргүүлж хараагаа онилов. Овоо хараанд торсон хөгшин чоныг газарт унагав. Хангайн сарьдгаас цас нурах шиг нүргэлэн, улангассан араатнууд зогтусан зогслоо. Буун дуу хоёр дахь удаагаа нүргэлэн, гичий чоно гаслан уналаа. Хэдэн бэлтрэгэн чоно уул руу эргэж мацав.

Дайзтай сумаа гаргаж, бутны хажууд тавьчхаад, хадан дээр тэвхийн зогсоод, буга явсан зүгт эргэж харав. Зузаан цасыг самнасан тахир зураас алсад мурилзаад алга болжээ.

Хөл дор нэг юм сүүтгэнэх шиг боллоо. Хамгийн түрүүнд буудсан хөгшин чоно дутуу шархдаад, өөдөөс нь мөлхжээ. Цасан доогуур шургалан зүтгэсээр, хадны дэргэд ирээд, биеэ хураан отож байлаа. Гэнэт сэхээрсэн залуу эр, эрсэлсэн чонотой тэмцэлдэхдээ өндөр хаднаас өнхрөн унав. Араа соёо нь гарт тэмтрэгдэн, сэгний үнэр хамар цоргив. Эрийн тулаан эцэстээ хүрэхэд, үхэл амьдрал дэндүү гоёдов. Чоно эрчээрээ дайрч, бахим савраар нүүр зурж, халуу оргиулаад, гал улаан ам нь гүрээ рүү зүтгэнэ.

Айж болохгүй. Айвал шоглоно. Амархан ялагдана... Залуу эр, нэг гараараа үс ноолуураас нь лавхан атгаад, нөгөө гараараа түрийгээ тэмтчив. Хутгаа суга татангаа, бөөрний орчимд нь хүчтэй бүлэв. Чоно гаслах дуулдав.

Очирхүү ухасхийн босоод хад өөд мацав. Бугаа аваад сумаа хайв. Харанхуйд тэмтчээд, нэг ч сум олсонгүй. Баруун гар нь зангиран, бугуйгаараа янгинаж байлаа. Цасан дээр налмайн унасан азарган чононоос уур савсан, агдасхийн татвалзав. Хадан дээр цомбойн суусан залуу эр хором амраад бослоо.

2023-2024 оны хичээлийн жил

Доод үзүүрээр тойрч, саахалт айлын гадаа ирлээ. Хоёр халтар нохой нь давхилдан ирснээ, Очирхүүг танилаа. Нялуун цусны үнэрт зогтусан зэвүүцэж, хэд хэд боргосноо холдов.

Араг сандайлж суугаад Өлзиймаа! гэж хэд хэд дуудлаа. Өрх нь бүтээлэгтэй жижиг гэрээс лааны гэрэл сэвэлзэн, нэг хүн гарч ирэв. Тэрээр, Очирхүүг хараад, уулга алдан гэртээ оруулжээ. Дээлийн энгэр хормой нь цусанд будагдаад, дарайтал хөлджээ. Очирхүү гараа харснаа, ханцуй дороо нуулаа. Баруун гарын хоёр хурууг нь тас хазаад, санжуулсан байлаа. Нүүрийн арьсыг духнаас нь эрүү хүртэл сэт татан уржээ. Өлзиймаа шарх бүрийг цэвэрлэн угааж, цэмбийтэл боож өгөв. Өөрийнхөө оронд оруулаад, хөнжлөөр хучин, дээрээс нь дахаа тавив.

Дөнгө өвгөний нойр сэрвэлзэж, отгон хүүгээ хүлээсээр үүр цайлгав. Дунд хүүгээ сэрээгээд, доод өвөлжөө рүү зүтгүүлжээ. Айж түгшсэн Дөнгө өвгөн хүүгийнхээ нүүрийг хараад, уулга алдав. Гарыг нь үзээд, халаглан шогшров. Гай зовлон дайраад өнгөрчээ. Арцалдаан дундаас амьдарсан хүүгээрээ бахархаж, сүрэг чонын зугаа болоогүйд баярлаж суув. Зудтай цагийн чоно шиг хөөрүү амьтан байдаггүй гэдэг.

Цаг тооллын жаран дөрвөн оны хар луу жил Очирхүү дөчин хоёр насыг зоогложээ. Өлзиймаа хайрт хүнийхээ дэргэд ханилан явсаар, дөрвөн сайхан хүүхдийг нь төрүүлж өгчээ.

Хүний өөдөөс эгцэлж боломгүй гүн шарх нүүрэнд нь үлджээ. Гэнэт харсан хүн цочихоор. Баруун гарын хоёр хуруу мухарлаад, айдас төрөм. Яагаад ч юм, бүү мэд? Уул тайгаар гав ганцаар явах дуртай болжээ. Заримдаа хүмүүс сүрэг чононоос дор. Бусдын зовлонд дуртай юм шиг авирлана. Элдэв нэр хоч өгч, тааварласан чигээрээ бахдан хэлэлцэнэ.

Нэг ёсондоо Очирхүү олны дунд нүүргүй явж ирлээ. Гэхдээ л <<нүүртэй>> эр хүн байлаа. Нүүртэй мөртлөө << нүүргүй>> эрчүүд зөндөө шүү дээ?!

Сум нэгдлийн түлээчин хийж, хориод жил ууланд ажиллав. Сумын төвд эгнэн боссон өнгөлөг барилгуудын хана дээвэр, туурга цонх бүрт Очирхүүгийн хөлс дусаж, зүтгэл шингэсэн билээ.

Уул хад, ой тайга руу зүглэхээс биш, өөр хаашаа ч явдаггүй түүнийг хотоос дууджээ.

-Хань минь! Хүний гадаад төрх хамаагүй, дотоод сэтгэл хамгийн чухал. Хичээл зүтгэл хөдөлмөр бүтээлийн үнэ цэн гэж бий. Чи минь жинхэнэ эр хүн шүү дээ! Нүүр дүүрэн яваад ир! гэсэн Өлзиймаагийнхаа үгэнд урам сэргэн, бэлдэж өгсөн юмсыг аваад, сэтгэлдээ жигүүр дэлгэн, хотод ирлээ.

Баярын хурал, зоогийн хүндэтгэл, радиогийн сурвалжилга, үдэшлэг цэнгүүн гээд хөтөлбөр журмын дагуу бүх ажиллагаанд оролцож, төрийн дээд шагналаар энгэрээ мялаав. Индэр дээр үг хэлээд буухад, хурлын заал дүүрэн хүмүүс, аадар бороо шиг нижигнэтэл алга ташихыг сонсоод, Очирхүү их баярлажээ.

Эр зориг, хичээл зүтгэл эцэстээ хүн бүхэнд хүлээн зөвшөөрөгддөг юм билээ. Гол чанар нь энэ аж.

Д.Мөнхбаатар

1. Очирхүүг цасан шуурганаар саахалт айл руу дуудах хүч юу байв? 2 оноо

-
-

2. Очирхүүгийн чонотой тулалдахдаа авсан шарх насан туршид сэтгэлийг нь зовоож байсныг илтгэх баримт 2-ыг олж бичээрэй. 2 оноо

.....
.....
.....

3. Зохиолоос малчин айлын нэг оройн зоогийг олж бичээд, эдгээр үгсээр ямар санаа илэрхийлэхийг зорьсныг тайлбарлаарай. /цас их орсон орой/ 2 оноо

Тодотгосон үг.....

.....

Тайлбар:

.....

МАТЕРИАЛ ЗАСАХ ЗӨВЛӨМЖ

Засагч багш нарт:

-Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, өгөгдсөн түлхүүрийг зөвлөмж болгон ашиглана.

-Оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

-Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7-даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

1. Очирхүүг цасан шуурганаар саahalт айл руу дуудах хүч юу байв? 1-ийг бичсэн бол 1 оноо

- Өлзиймааг гэх сэтгэл
- Бусдын төлөө гэсэн сэтгэлтэй явах хүний ёс

2. Очирхүүгийн чонотой тулалдахдаа авсан шарх насан туршид сэтгэлийг нь зовоож байсныг илтгэх баримт 3-ыг олж бичээрэй. 1 баримт бичвэл 1 оноо, огт бичээгүй бол 0 оноо гэх мэт

- Уул хадаар тэнэх дуртай болсон
- Өөр хаашаа ч явдаггүй байсан
- Эхнэрийнхээ хэлсэн үгэнд урам сэргэн, жигүүр дэлгэсэн
- Хүмүүсийн алга ташилтад маш их баярласан.

3. Зохиолоос малчин айлын нэг оройн зоогийг олж бичээд, эдгээр үгсээр ямар санаа илэрхийлэхийг зорьсныг тайлбарлаарай. /цас их орсон орой/ Оройн зоог олж бичвэл 1 оноо, тайлбар бичвэл 1 оноо гэх мэт

- аяга бүлээн цай, бүхэл мах, өтгөн шөл
- Тайлбар: Өдөржин завгүй байсныг бас ихэд ядарсныг, даарсныг илтгэж байна.

4. Хүний гадаад төрх хамаагүй, дотоод сэтгэл хамгийн чухал....гэсэн өгүүлбэрт баймж бүтээвэр нэмж өнгө аясыг өөрчлөн бичээрэй.

Зөв хариулт бүрт-1 оноо

/хүүхэд ямар ч хувилбарыг бичсэн байж болох/

5. Дараах өгүүлбэрийг ямар өгүүлбэр болохыг тодорхойлоод, энгийн өгүүлбэр болгон задлан бич. Зөв тодорхойлсон бол 1 оноо, зөв задлан бичсэн бол 2 оноо гэх мэт

- ОГӨУНӨ
- Араас нэхнэ.
- Хөөсөн чононууд.
- Чононууд 0.

6. “Заримдаа хүмүүс сүрэг чононоос дор. Бусдын зовлонд дуртай юм шиг авирлана. Элдэв нэр хоч өгч, тааварласан чигээрээ бахдан хэлэлцэнэ.” гэсэн хэсгээс өөрт төрсөн бодлоо 30-40 үгэнд багтаан илэрхийлээрэй.

- Өөрийн санааг бүрэн дүүрэн илэрхийлж бичсэн бол- 4 оноо
- Санаагаа боломжийн түвшинд илэрхийлсэн-3 оноо
- Санаагаа дундаж гаргасан- 2 оноо
- Санааг давтан хуулж бичсэн багахан тайлбар хийсэн-1 оноо
- Огт бичээгүй бол- 0 оноо

7. Кирил бичгээс үндэсний бичигт буулгаарай.

- Бүгдийг зөв хөрвүүлсэн бол 5 оноо
- 1-2 үг алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо
- 3-4 үг алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо
- 5-6 үг алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо
- 7-8 үг алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо
- 9 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

2023-2024 оны хичээлийн жил

8. Эр зориг, хичээл зүтгэл эцэстээ хүн бүхэнд хүлээн зөвшөөрөгддөг гэдгийг уг эхэд харуулжээ. Тэгвэл найз нөхдийнхөө эр зоригийг хурцалж, амжилтад уриалан дуудагч нь чи ч байж болох шүү дээ. Чи чадна аа гэдгийг найздаа ойлгуулж ятган сэнхрүүлэх утга бүхий эсээ зохион бичээрэй. /Үгийн тоо 250-300/

Үнэлэх схем

<i>агуулга</i>	<i>оноо өгөх заавар</i>	<i>оноо</i>
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж, эхийг бүхэлд нь учир шалтгааны уялдаа холбоотой бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо, цаг хугацаа, үйл явдлын дараалал бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч сэдвийн дагуу бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл нэг үйл явдлыг биш хэд хэдийг бичсэн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Дүр дүрслэл	Дүр, дүрслэлийг оновчтой ашигласан бол	2
	Оновчтой биш ч дүрслэх ур маяг ашигласан бол	1
	Дүрслэх ур маяг ашиглаагүй, хүний хэлсэн үг зэрэг нь ялгарч мэдэгдэхээргүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэв маяг	Эх бүхэлдээ хүүрнэсэн өнгө аястай бол	2
	Эхийн ихэнх хэсэг хүүрнэсэн бол /дүр, орчноо танилцуулах гээд хэт их тоочих зэрэг алдаа гарсан бол/	1
	Эх бүхэлдээ өөр хэв маягтай бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй бол	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	180-210 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X

.....сургуулийн.....ангийн сурагч..... овогтой.....

“Б” ХУВИЛБАР

80 МИНУТ

Хуучин ном

Нэг мэдсэн чинь өвгөн байрныхаа гадаах сүүдрэвчинд “Яана гэнээ чи. Насандаа нэг бүтэн ном уншиж үзээгүй байж үлдсэн гурван номыг минь авах гэнээ чи. Хэзээ байтлаа чи номонд ингэтлээ хайртай болчихоов. Би ямар чамайг мэдэхгүй биш. Тэгж ч ярихгүй ээ хүү минь” гэсэн уур унтуунд ороогдон нилээн амьсгаатай сууж байв. “Наад муу цаасыг чинь хэн ч уншихгүй за юу, зарагдах ч үгүй. Харин ч би ганц нэгээр нь зарж өгч байгаад баярла. Одоо та нарыг уншдаг хүн гэж хаа байсан юм. Та нарын үе чинь өнгөрч байна шүү дээ, хөгшин зөнөгөө.” хэмээн чарлах согтуу хүүгийнх нь дуу чихэнд нь хадна.Цээжнийх нь гүнээс гомдол харууслын хар манан багтаж ядан огшиж, хүүгийн тухай бодол урсгал зөөлөн харцыг бүрхэн нулимс болон тунарсан ч зовхио давалгүй үлдэв.

Дахин нэг санаа алдсан өвгөн- За, за. Энд ингэж суугаад яахав. Аягүй бол байрны хэдэн хөгшин мөдхөн гарч ирнэ. Тэгээд л нэг их хийх ажилтай болсон юм аятай муу хүүг минь муулцгаах юм болох биз гэж амандаа үглэх нь саяхан эгээтэй л зодуулчхаагүйгээ албаар мартан, ганц хүүгээ өөрийнхөө бодлоос ч, өрөөлийн амнаас ч өмөөрч буй бололтой.Өвгөн малгайгаа өмсөх гэтэл гурван ном хийсэн нэг муу даавуун уут бугуйнд нь санжих ажээ. Хүүгийнх нь агсам тавих шалтаг ердөө л энэ. Хэдэн жилийн өмнө нутгийнх нь том ой болж нутгийн зөвлөл нь буурал зохиолчийн номыг хэвлүүлж өгсөн юм. Магнайгаа хагартал баярласан өвгөн номын дэлгүүрээр хэдэн номоо тараадаг ажилтай болсонсон. Тэрнээс хойш бараг хоёр жил өнгөрөө юу даа. Өнөөдрийн энэ гурав хамгийн сүүлчийнх нь. Заримыг нь хүн хард бэлэглэсэн байх, зарим нь ч зарагдсан байх. Ихэнх нь чухам хаачсаныг өвгөн мэдэхгүй. Үнэн хэрэгтээ өвгөнөөс илүүтэйгээр уг номыг хүү ньборлуулсан гэхэд болно.

Өвгөн өөрийнхөө явдаг, тэр байтугай амьдралынхаа ихэнх үед алхаж өнгөрөөсөн тэр л гудамжаараа явж байлаа. Хүн харахад гэлдрэх авч өөртөө бол нэлээд дориухан алхаж явна. Хэд хэдэн их сургууль зэрэгцэн орших энэ гудамжинд цаг цагийн оюутан залуус хөлхөлдөн байдаг тул ёстой л мөнхийн залуу гудамж гэлтэй. Энд бас гадаад монгол холилдсон нэртэй нэгэн номын дэлгүүр бий. Өвгөн өөрийн мэдэлгүй тийшээ явж байгаа. Энд ирж номын далайд умбан, орчноосоо тасран жаргадаг гэж байгаа. Усан дунд ямар ч том амьтан хүнддэггүй шиг номон дунд байхдаа өвгөн хэзээ ч хөгшддөггүй юм. Юу ч худалдаж авахгүй хэрнээ тэр номнуудыг гарчигласан шиг явах нь түүнд юутай ч зүйрлэшгүй жаргал болно.

Өвгөн номын дэлгүүртээ ирлээ. Дэлгүүрийн хүүхэн түүний нэг ном зарагдсан тухай баясангүй өгүүлээд номны тооцоо болох зургаан мянга хоёр зуун төгрөг өглөө. Зарим хүнийх хорь гучаараа зарагддаг байхад өвгөнийх бараг гурван сарын хугацаанд ганцхан зарагдаж. “Одооны хүмүүс ном бага уншиж байна гэж би хэлэхгүй ээ. Цаг цагт хүмүүс ном уншиж л байсан. Уншсаар ч байх болно. Харин хүүгийн хэлснээр намайг л хүмүүс уншихаа больсон нь үнэн бололтой. Хоцрогдоно гэдэг нь энэ юм байх аа даа. Хөөрхий, миний номыг авсан хүний буян нь дэлгэрч яваг. Надад ямар их тус хийж яваагаа мэдэхгүй л яваа байх даа, зайлуул” гэж бодон хүүтэйгээ булаацалдан байж авчирсан сүүлчийн номнуудаа худалдагчид өгөв.

Энгэрийнхээ дотуур халаасанд мөнгөө лавхан хийсэн өвгөн сурсан зангаараа дэлгүүрийн тавиур дээрх номнуудыг нүд гүйлгэн явна. Тавиураас тавиур хооронд тэр байтугай номноос номны хооронд түүний бодол тэлээлэн урсана. “Энэ зохиолч хүү лав миний хүүгээс насаар дүү дээ. Гэтэл ийм сүрхий байх гэж. Хүүгээ би зохиолч бол гэж шаардаагүй шүү дээ. Зүгээр л номыг сэтгэл зүрхнээсээ уншдаг хүн болоосой гэж хүссэн. Тэгсэн бол өдийд амьдралд хайртай хүн явахгүй юу. Юу боллоо гэж хамаг байдгаа өөрийн гараар үгүй хийж явахав” гэсэн бодол нь харуусал болон хувирав.

Удалгүй өвгөн номын дэлгүүрийн нөгөөх л эргэлддэг хаалгаар гараад гудамж өгсөн гэлдрэв. Усан сангийн чулуун хашлаган дээр хэсэг хүмүүс хуучин ном зардаг болжээ. Өвгөн тэрийг тойрч чадсангүй. Ганц нэг ном үзэн, авахгүй ч гэсэн үнийг нь сонирхон явав.

Тэгтэл . . . Өвгөний нүдний буланд нэгэн халцархай хүрэн хавтастай ном сэрвэлзэн үзэгдэв. Шаргалтаж хуучирсан хуудас нь ямар нэгэн далдын совин даллах мэт зөөлөн намирах тэр номыг хараад өвгөний зүрх өөрийн эрхгүй хурдан хурдан цохилж, амьсгаа нь давчдаж ирэх нь тэр.

- Мөн байна. Эвий минь гэж.Тэр чигээрээ мөн байна гэж эвгүй саарал хоолойгоор цахиртан дуугараад, номыг амандаа барин үнсэх ая үзүүлэхэд ном зарж байсан тарган бор авгай ухасхийн босож -Та дийлэхгүй ээ, дийлэхгүй гэж хэлээд өвгөний гараас номыг шувт татан авч буцааж тавив. Өвгөн дахин номыг авч зүрхэлсэнгүй.“Яг мөн байна. Дөчин хоёр жилийн өмнө хэвлүүлсэн миний анхны ном мөн байна. Намайг зохиолч хэмээн зарласан анхны ном. Чамайг хэвлүүлчхээд ёстой л нэг анхны хүүхдээ төрүүлсэн эх хүн шиг баярласандаа цээжээ дэлдэн гүйж явсан сан. Хожим нь өөрөө олж авах гээд чадаагүй юмдаг. Гэтэл өтөл насны шувтарга дээр ингэж таарах гэж. Ерөөсөө худалдаж авдаг хэргээ” гэж бодоод эргэж очин энгэрээ тэмтрэн зогсохдоо

“Би одоо энийг аваад ч яах юм билээ. Хэндээ ч гэж авч очих юм. Манай тэрэнд “Энэ аавын минь анхны ном юм шүү” гээд нандигнаад явах ухаан ямар байх биш. Тэгснээс хэн нэгэн сонирхсон хүн нь аваг дээ” гэж бодон өвгөн цааш эргэлээ. Гэхдээ тэр шуудхан яваад өгч чадсангүй. Үрдээ хоргодох амьтан шиг эргэж хургасаар байв. Үд хэвийхийн алдад нэгэн залуухан хүү ирж хуучин номыг эхнээс нь үзэж явснаа яг өвгөний номыг авч эргүүлж тойруулан хэсэг үзээд юу юугүй авах болов.“Миний номыг энэ олон жилийн дараа ч гэсэн хүн худалдаж авсаар, уншсаар байна шүү дээ. Би амьд байгаа юм байна. Үүн шиг сайхан юм гэж байх уу” гэсэн гэрэлт бодол харван орж ирэхүйд туранхай хатингар цээжинд нь омогшил төрөн, ус гүйсэн үлбэгэр нүдэнд нь үл мэдэг оч гэрэлтэн эргэн тойрноо харав. Өдөржингөө шахам гадаа суусан тэр ам ангаснаа сая ухаарч хажууханд зарж буй квасаас нэг аягыг авч залгилав. Хоолой сэрүү татаад даанч нэг сайхан. “Миний цангаа тайлах ч яахав. Өнөө муу хүү маань бүр харангадаад үхэх гэсэн юм хэвтээ байх даа.. Энэ хэдэн төгрөгөөр би яагаа ч билээ. Сүүтэй сүүгүй болох л байлгүй яав гэж. Хүүдээ уух юм авч өгдөг юм билүү дээ. Өнөө маргаашгүй болсон би хэд насална гэж хүүдээ хатуурхаж явахав. Намайг унаад өгөхөөр ухаан суух биз.” хэмээн бодох өвгөн зохиолч хүнсний дэлгүүр лүү алхав. Хүн харахад гэлдэрч явах шиг боловч үнэндээ бол тэр дэгдэж явлаа. Тэрээр “За байз, таван мянга есөн зуун төгрөг үлдсэн юмсан. Саяын квасыг хэрэггүй ч уув уу . . .” хэмээн гэнэтхэн санаашрав . . .

Т.Бум-Эрдэнэ

1. Хүүдээ ихэд гомдсон ч эцгийн хайр аугаа болохыг батлах баримт 2-ыг олж бичээрэй. 2 оноо

-
-

2. Тодруулсан хэсгээс тухайн хүн өндөр настай гэдгийг илэрхийлэх үг 4-ийг олж бич. / үг давтахгүй гэдгийг анхаараарай./ 2 оноо

-
-
-
-

3. Номын дэлгүүрт байхдаа авдаг мэдрэмжийг илэрхийлсэн дүрслэлийг жишээ олж бичээд тайлбарлаарай. 2 оноо

дүрслэл -

тайлбар -

дүрслэл -

тайлбар -

4. Эрдэм номын мөр хөөсөн, ном уншдаг хүмүүсийг өвгөн хэрхэн дүгнэсэн бэ? 3 оноо

МАТЕРИАЛ ЗАСАХ ЗӨВЛӨМЖ

Засагч багш нарт:

-Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, өгөгдсөн түлхүүрийг зөвлөмж болгон ашиглана.

-Оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

-Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7-даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

1. Хүүдээ ихэд гомдсон ч эцгийн хайр аугуу болохыг батлах баримт 2-ыг олж бичвэл 2 оноо гэх мэт

- Аягүй бол байрны хэдэн хөгшин мөдхөн гарч ирнэ. Тэгээд л нэг их хийх ажилтай болсон юм аятай муу хүүг минь муулцгаах юм болох биз
- Миний цангаа тайлах ч яахав. Өнөө муу хүү маань бүр харангадаад үхэх гэсэн юм хэвтээ байх даа.. Энэ хэдэн төгрөгөөр би яагаа ч билээ. Сүүтэй сүүгүй болох л байлгүй яав гэж. Хүүдээ уух юм авч өгдөг юм билүү дээ.

2. Тодруулсан хэсгээс тухайн хүн өндөр настай гэдгийг илэрхийлэх үг 1-ийг олж бичвэл 0.5 оноо. /үг давтахгүй гэдгийг анхаараарай./

- Өвгөн
- Хөгшин зөнөг
- Үе нь өнгөрсөн
- буурал

3. Номын дэлгүүрт байхдаа авдаг мэдрэмжийг илэрхийлсэн дүрслэлийг жишээ олж бичээд тайлбарлаарай. 1 дүрслэл олж тайлбарлаж бичихэд 1 оноо

- Орчноосоо тасран жаргах-утгыг тайлбарлах
- Номын далайд умбах-утгыг тайлбарлах

4. Эрдэм номын мөр хөөсөн, ном уншдаг хүмүүсийг өвгөн хэрхэн дүгнэсэн бэ? 1 дүгнэлт олж бичихэд 1 оноо гэх мэт

- Цаанаа л нэг гэгээхэн
- Амьдралд хайртай хүн болдог
- Сүрхий хүн

5. Дараах өгүүлбэрийн үг сонголтыг ажиглан зохиогч ямар санаа илэрхийлэхийг зорьсныг тайлбарлан бичээрэй. Тайлбарлан бичсэн байдлаас харгалзан зохих оноог өгнө.

- Хүн харахад гэлдрэх авч өөртөө бол нэлээд дориухан алхаж явна.- Настай хүний алхаа удаан. Гэсэн ч өөрийн дассан газар, дуртай газар руугаа явж байгаа учраас сэтгэл дүүрэн байгаа байдлыг илэрхийлсэн г.м
- Хүн харахад гэлдэрч явах шиг боловч үнэндээ бол тэр дэгдэж явлаа.- сэтгэл нь өөрийгөө залуу байгаа шиг бодож байгаа гэдгийг харуулсан. Өтлөөгүй, нас хөгшрөөгүй гэсэн санаа харуулсан г.м

6. “Усан дунд ямар ч том амьтан хүнддэггүй шиг номон дунд байхдаа өвгөн хэзээ ч хөгшдөггүй юм.” гэсэн хэсгийг өөрийн үзэл бодлоор тайлбарлан бичээрэй. Үгийн тоо 30-40

- Өөрийн санааг бүрэн дүүрэн илэрхийлж бичсэн бол- 3 оноо
- Санаагаа дундаж гаргасан- 2 оноо
- Санааг давтан хуулж бичсэн багахан тайлбар хийсэн-1 оноо
- Огт бичээгүй бол- 0 оноо

7. Кирил бичгээс үндэсний бичигт буулгаарай.

- Бүгдийг зөв хөрвүүлсэн бол 5 оноо
- 1-2 үг алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо
- 3-4 үг алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо
- 5-6 үг алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо
- 7-8 үг алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

2023-2024 оны хичээлийн жил

● 9 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

8. Одооны хүмүүс ном бага уншиж байна гэж би хэлэхгүй ээ. Цаг цагт хүмүүс ном уншиж л байсан. Уншсаар ч байх болно. гэсэн өвгөний бодлыг баримт мэдээллээр баяжуулан баталж нотолсон эх зохион бичээрэй.

/Үгийн тоо 250-300/

Үнэлэх схем

агуулга	ОНОО өгөх заавар	ОНОО
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж, эхийг бүхэлд нь учир шалтгааны уялдаа холбоотой бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо, цаг хугацаа, үйл явдлын дараалал бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч сэдвийн дагуу бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл нэг үйл явдлыг биш хэд хэдийг бичсэн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Дүр дүрслэл	Дүр, дүрслэлийг оновчтой ашигласан бол	2
	Оновчтой биш ч дүрслэх ур маяг ашигласан бол	1
	Дүрслэх ур маяг ашиглаагүй, хүний хэлсэн үг зэрэг нь ялгарч мэдэгдэхээргүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэв маяг	Эх бүхэлдээ хүүрнэсэн өнгө аястай бол	2
	Эхийн ихэнх хэсэг хүүрнэсэн бол /дүр, орчноо танилцуулах гээд хэт их тоочих зэрэг алдаа гарсан бол/	1
	Эх бүхэлдээ өөр хэв маягтай бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй бол	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	180-210 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X